

**БАТЛАВ.
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА**

Г.ЭНХМӨНХ

**ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ГРАНД ЗОТОЛ ЭНЕРЖИ” ХХК
ЗАХИРАЛ**

Б.БОДОХ

**“ГРАНД ЗОТОЛ ЭНЕРЖИ” ХХК ИЙН СҮХБААТАР АЙМГИЙН НУТАГТ
ХЭРЭГЖИХ “БАРУУН-УРТ ХОТЫН 70 МВТ-ЫН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”- ИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 7055993/**

**ХЯНАСАН:
ХБОВЗГ ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ
БОЛОВСРУУЛСАН:**

**“ГРАНД ЗОТОЛ ЭНЕРЖИ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН**

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ТАЛБАЙН БАЙРШИЛ.....	2
1.1. Төслийн нэр:.....	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгч:.....	2
1.3. Төслийн талбайн байршил.....	2
1.4. Төслийн ерөнхий мэдээлэл, хүчин чадал, технологи, дэд бүтэц.....	3
1.4.1. Төслийн ТЭЗҮ-д тусгаснаар.....	3
1.4.2. Төслийн талбай, байршил ба дэд бүтэц.....	3
1.4.3. Зуухны технологи ба түлшний хэрэглээ.....	4
1.4.4. Нүүрс тээвэрлэлт, хадгалалт ба тоосжилтын бууруулалт.....	4
1.4.5. Утаа, үнс болон шаарга зайлуулах технологи.....	4
1.4.6. Үнсийг дахин ашиглах боломж.....	5
1.4.7 Яндан, ус хангамж ба үндсэн барилгын шийдэл.....	5
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1. Талбайн байршил.....	6
2.2. Газрын гадарга хэвлий.....	6
2.3. Уур амьсгал.....	6
2.4. Агаарын чанар.....	6
2.5. Усан сүлжээ.....	6
2.5.1. Гадаргын ус:.....	7
2.5.2. Газар доорх ус:.....	7
2.6. Хөрсөн бүрхэвч.....	7
2.7. Ургамалан нөмрөг.....	7
2.8. Амьтны аймаг.....	8
2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг.....	8
2.10. Түүх, соёлын дурсгалт газар.....	8
2.11. Нийгэм эдийн засгийн байдал.....	8
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН.....	10
ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	10
3.1. Төслийн гол сөрөг нөлөөллүүд.....	10
3.2. Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрд үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	11
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА	13
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
5.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
5.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
5.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
5.5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	22
5.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	22
5.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	24
5.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	24

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ТАЛБАЙН БАЙРШИЛ

1.1. Төслийн нэр:

Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц байгуулах төсөл


1.2. Төсөл хэрэгжүүлэгч:

“Гранд зотол энерги” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011868316; Регистрийн дугаар: 7055993;

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 39 тоот. Утас: 99118356, 88041935

1.3. Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Таван-Эрдэнэ (8-р) багийн нутагт нутаг дэвсгэрт Баруун-Урт хотын төвөөс зүүн өмнөд тийш 3 км-ийн зайд, Баруун-Урт сум руу чиглэсэн орон нутгийн чанартай авто замын дагуу оршиж байна.



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршил

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн эзэмшил газрын хэмжээ 30 га бөгөөд талбайн булангийн цэгүүд ба талын уртыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Талбайн булангийн цэгүүд (30 га)

Хүснэгт №1-1.

№	Уртраг	Өргөрөг	Урт
1	677292.11	5169234.68	427.85
2	677567.40	5169562.20	687.20
3	677041.16	5170004.52	434.51
4	676764.82	5169669.23	683.02


1.4. Төслийн ерөнхий мэдээлэл, хүчин чадал, технологи, дэд бүтэц

1.4.1. Төслийн ТЭЗҮ-д тусгаснаар Төслийн хүрээнд байгуулагдах 70 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг хоёр ээлжээр ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ба эхний ээлжид 35 МВт ашиглалтад орно. Энэ нь тухайн бүс нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ болон цахилгаан дамжуулах агаарын шугамын нэвтрүүлэх чадвартай холбоотой аж. Эхний блок ашиглалтад орсноос хойш 5 жилийн дараа дараагийн 35 МВт ашиглалтад орох бөгөөд Сүхбаатар, Дорнод аймгуудыг ТБНС-тэй 220 кВ-ын шугамаар холбон бүрэн хүчин чадлаараа ажиллахаар төлөвлөсөн байна.


1.4.2. Төслийн талбай, байршил ба дэд бүтэц Төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын орчимд дулааны цахилгаан станц барихаар төлөвлөсөн. Станцын талбай нь ойролцоогоор 30 га бөгөөд төв замаас 90–110 м, сумын гадна тойргоос 1250 м, цэвэрлэх байгууламжаас 800 м орчим зайд, далайн түвшнээс дээш 950–953 м өндөрт байрлана. Одоо ажиллаж буй дулааны станцаас ойролцоогоор 4 км зайтай. Талбайд зуух, турбины барилга, хими-ус цэвэрлэгээний байгууламж, нүүрсний нөөцийн талбай, агаарын хөргөлттэй конденсатор, цахилгаан хуваарилах байгууламж, захиргаа болон засвар үйлчилгээний барилга байгууламжуудыг байрлуулахаар төлөвлөсөн.

Нүүрсийг Тал булаг болон Төхөмийн уурхайгаас авто тээврээр нийлүүлэх бөгөөд станцын хэрэгцээнд жилд хамгийн ихдээ 552.2 мянган тонн нүүрс авахаар тооцсон. Усны хэрэглээг одоо байгаа Баруун-Урт хотын ус хангамжийн системээс хангахаар төлөвлөсөн.

Үндсэн барилга байгууламжийг технологийн дараалалд нийцүүлэн байрлуулж, турбин/генераторын байр болон зуухны байрыг тусад нь төлөвлөсөн. Нүүрсний бункер, деаэратор, удирдлагын өрөө завсрын блокт байрлана. Утааны хийн цэвэрлэгээнд уутат шүүлтүүр ашиглах бөгөөд хоёр зуухны дунд 120 м өндөр яндан төлөвлөсөн.



Зураг 2. Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд баригдах 70 МВт-ын ДЦС-ын барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт



Үнс, шаргыг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон усны хэрэглээг бууруулахын тулд хуурай аргаар зайлуулах технологи сонгосон. Тал булгийн нүүрсээр ажиллах үед нэг зуухнаас цагт нийт 6.42 тонн үнс, шаарга, хоёр зуухнаас нийт 12.84 тонн үүсэх тооцоотой.

Нарийн үнсийг тусгай бункерт хуримтлуулж, машинаар тээвэрлэх эсвэл хэрэглэгчдэд нийлүүлэх боломжтой. Шаргыг мөн хуурайгаар зайлуулж, тусгай бункерт хадгалан хаягдлын талбайд тээвэрлэнэ. Үнс зайлуулах системийг автомат, гар болон туршилтын горимоор удирдах боломжтой.

1.4.6. Үнсийг дахин ашиглах боломж Төслийн нэг чухал байгаль орчны шийдэл нь нүүрсний шаталтаас үүсэх дэгдэмхий үнсийг хаягдал бус, эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм. Дэгдэмхий үнс нь цемент, бетон, тоосго, хавтан зэрэг барилгын материалын үйлдвэрлэлд эрдэс нэмэлт болгон ашиглах боломжтой.

Монгол Улсад цементийн үйлдвэрлэлд үнс ашиглах боломж байгаа бөгөөд Сүхбаатар аймагт цаашид тоосго, блок, замын хавтан зэрэг барилгын материалын үйлдвэрлэлд ашиглах боломжтой гэж төсөлд үзсэн. Ингэснээр үнсийг булшлах хэмжээг багасгаж, хөрсний бохирдлыг бууруулахын зэрэгцээ нэмэлт орлого бий болгох боломжтой.

Үнсийг хадгалах зориулалтаар битүү SILO төрлийн агуулах байгуулах боломжийг авч үзсэн. 14,000 м³ багтаамжтай агуулахын хөрөнгө оруулалтын тооцоо, үнс борлуулснаар бий болох боломжит орлогыг төсөлд тусгасан.

1.4.7 Яндан, ус хангамж ба үндсэн барилгын шийдэл. Станцын хоёр зуух бүрэн хүчин чадлаар ажиллах үед утааны хийн хэмжээнээс хамааран яндангийн хэмжээг тооцсон. Хоёр зуух ажиллах үндсэн хувилбарт 120 м өндөр яндан, гарах хэсгийн ойролцоогоор 3 м диаметртэй байхаар авч үзсэн. Ирээдүйд гурван зуухтай болох өргөтгөлийн үед яндангийн диаметрийг 4 м хүртэл нэмэгдүүлэх боломжтой гэж тооцсон.

Усны хэрэглээг Баруун-Урт хотын одоо байгаа ус хангамжийн системээс хангана. Хотын усан хангамж нь газрын доорх усны эх үүсвэр, гүний худаг, усан сан болон насосын системд тулгуурладаг.

Үндсэн барилга байгууламжийг тухайн бүс нутгийн эрс тэс уур амьсгалд тохирсон стандарт, нормын дагуу барихаар төлөвлөсөн. Барилга нь ган каркас, хөнгөн хосолмол хийцтэй байх бөгөөд ажиллагсдын эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгаалалтын шаардлагыг хангана. Тоног төхөөрөмжийн суурийг ус, тос, хүчил, шүлт нэвчихээс хамгаалж, галын аюулгүй байдал, агааржуулалт, цэвэр бохир ус, дохиолол зэрэг инженерийн системийг иж бүрнээр төлөвлөсөн.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Талбайн байршил

“Гранд зотол энерги” ХХК-ийн “Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Таван-Эрдэнэ (8-р) багийн нутагт нутаг дэвсгэрт байршина. Тус дулааны цахилгаан станцын нийт талбай нь 30 га байна.

2.2. Газрын гадарга хэвлий

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их муж (IV)-ийн Халхын дундад ба Дарьгангын талархаг муж (IV.1)-ийн Дорнод хотгорын тойрогт хамаарна.

Төлөвлөлтийн талбайн газрын гадарга нь харьцангуй тэгш, далайн түвшнээс дээш дунджаар 952 метрт өргөгдсөн тал хээрийн хэв шинжид хамаарагдана. Төлөвлөлтийн талбайн газрын гадарга нь “Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар дахь ангиллаар нэн тохиромжтой ангилалд хамаарч байгаа бөгөөд өндрийн хэмжээ далайн түвшнээс дээш 975-983 метрийн өндөр байна. Төлөвлөлтийн талбайн газрын гадарга нь харьцангуй тэгш, хамгийн налуу хэсэгтээ 12 градус байгаа бол хамгийн налуу бага хэсэгтээ 0.01 метрт байна.

2.3. Уур амьсгал

Сүхбаатар аймгийн Дулааны улирлын агаарын дундаж температур 4.9-21.8⁰ С градус орчим дулаан байдаг бөгөөд 6, 7-р сард агаарын хамгийн макс утга нь 31.8-37.9⁰С градус, хөрсний макс 55- 63⁰С хүрч халдаг тул агаар хөрсний температурын хэлбэлзэл их байдаг байна. Хоногийн агаарын дундаж температур -5⁰ дайрч хүйтрэхээс эхлээд -5⁰ дайрч дулаарах үеийг өвлийн улиралд тооцдог. 11-р сарын 1-5-ны орчимд -5⁰ дайрч хүйтрэн өвөл эхэлж, 3-р сарын 20-23 хооронд -5⁰дайрч дулааран хавар болдог буюу 142-147 хоног буюу 4 сар гаруй өвөл үргэлжилдэг. Хүйтний улирлын агаарын дундаж температур 2.1...-21.3⁰С хүйтэн байдаг ба Баруун-Урт сум орчмоор 1, 2-р саруудад агаарт хамгийн минимум хүйтэн нь -25.9...-32.5⁰С орчим хүрч хүйтэрдэг. Мөн энэ саруудад хөрсөн дээр минимум нь -38...- 43⁰С орчим хүрдэг байна.

Хуурай дулаавтар уур амьсгалтай бүсэд багтах ба жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 45-65% байдаг. Тус аймгийн нутагт олон жилийн дунджаар 200.6 мм тунадас орох боловч гантай жил 101.5-111.5 мм болж эрс багасдаг байна. Хүйтний улирал болох 1-3, 10-12 дугаар саруудад хамгийн бага тунадас дунджаар 1.5-10.5 мм, дулааны улирал болох 4-9 дүгээр саруудад дунджаар 4.9-56.7 мм тунадас ордог байна.

Салхины дундаж хурд 2.7-4.6 м/с байдаг. Салхины горимын явцаас харахад хавар, намартаа салхины хурд ихсэж, зун өвөлдөө буурдаг зүй тогтолтой байна. Салхины зонхилох хурд Баруун хойноос 37.1%, Баруунаас 17.8%, Зүүн хойноос 14.5%-тай ихэвчлэн салхилдаг. Цаг агаарын онц аюултай үзэгдэл болох 40 м/с-ээс дээш хүчтэй салхи хавар 4, 5 дугаар сард ажиглагддаг боловч нийт хүчтэй салхины 2%-ийг эзэлдэг. Харин 3, 4 дүгээр сард 16 м/с дээш хүчтэй салхи 15-23 орчим өдөр ажиглагддаг нь тус нутаг салхи шуурга ихтэй бүс нутагт хамрагддаг байна.

2.4. Агаарын чанар

“Гранд зотол энерги” ХХК-ийн “Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь өнөөгийн байдлаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа учир талбайн агаарын чанар нь өнөөгийн түвшинд ямар нэгэн бохирдол, өөрчлөлт байхгүй, эх газрын хуурай цэнгэг төлөв байдалтай байна.

Агаар бохирдуулах эх үүсвэрээс ялгарсан бохирдуулагчдын тархалт сарнилт нь тухайн газар нутгийн газрын гадаргын хотгор гүдгэрийн байдал, цаг уурын хүчин зүйлс болох агаарын температур, салхины зүг, хурднаас ихээхэн хамааралтай байдаг. Агаарын бохирдолын хувьд Өвлийн улиралд гэр хорооллын түүхий нүүрсний хэрэглээ болон нам даралтын зуухнуудаас үүдэлтэй агаарын бохирдол (хөө тортог, хүхэрлэг хий) ихэсдэг.

Төслийн талбай болон түүний эргэн тойронд ямар нэгэн агаарын бохирдлын эх үүсвэр байхгүй байна.

2.5. Усан сүлжээ

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь ус зүйн хувьд Умард говийн гүвээт-Халхын дундад тал сав газарт багтаж байна.

2.5.1. Гадаргын ус: Гадаргын усан сүлжээ нь тухайн талбайн хэмжээнд бэсрэг гуу жалга, хуурай сайрын дагуу үүссэн байдаг. Бүс нутгийн хэмжээнд уулс хоорондын хотгор, хөндийн төв хэсгээр улирлын горимтой бөгөөд агаарын хур тунадсаар шууд нөхөн сэлбэгдэж тэжээгдэж буй ил задгай гадаргын усан сан бүхий олон тооны тойром, цөөрөм болон намгархаг чийгтэй цав газар харьцангуйгаар түгээмэл ажиглагддаг. Дулааны цахилгаан станц байгуулагдах талбайгаас зүүн, зүүн урд, урд, баруун урд талаар 7.6-26.5 км зайд том, жижиг, устай усгүй 41 тооны нуур, тойром байна.

2.5.2. Газар доорх ус: Газрын газрын доорх усны ашиглалтын нөөц баялгийн үнэлгээг Сүхбаатарын уулс хоорондох хотгорын өмнөд бортод орших газрын доорх усны Шовдол-Овоо” хэмээх ордод гидродинамик аргаар нийт 7000 м³/хон- оор буюу 80.8 л/с-ээр өгч үүнээс А зэргээр 1800 м³/хон, В зэргээр 1700 м³/хон, С₁ зэргээр 3500 м³/хон гэж тогтоосон байна. Төслийн ТЭЗҮ-д тусгаснаар дулааны цахилгаан станцын усны хэрэглээг одоо байгаа Баруун-Урт хотын ус хангамжийн системээс хангахаар төлөвлөсөн байна. ТЭЗҮ-д тусгаснаар дулааны цахилгаан станцын ус хэрэглээ 150 м³/ц буюу 3600 м³/хон болохоор байна. Нормын дагуу тооцоолбол 9398.5 м³/хон болж байна.

Тус ордын газрын доорх ус нь химийн найрлагаараа гидрокарбонат-натрийн найрлагатай, эрдэсжилт 0.9 г/л, ерөнхий хатуулаг 4.95-7.5 мг-экв/л, зарим хэсэгт үүнээс их байна. Газрын доорх усны тухайн ордыг аймгийн төвийн усан хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар ашиглаж байна. Газрын доорх усны ордын ус татах байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын 3-р бүсийн талбай 7874218 км² болно.

2.6. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбай нь Хөрс газарзүйн мужлалтаар Хотгорын бүсшилтэй, Хангайн их мужийн, Монголын Дорнод мужийн Баруун-Уртын тойрогт багтах ба Хээрийн судалгаа, лабораторийн мэдээнээс үзвэл судалгааны талбайд хүрэн, хээржсэн нугын шинжтэй хүрэн хөрсний хэв шинжүүд тархсан байна. Төсөл хэрэгжих талбайд хүрэн хөрс хамгийн их тархалттай буюу 26.01 га талбайг эзэлнэ. Төслийн талбайд баруун хойноос, зүүн урагш чиглэлтэй геоморфологийн хөгжлийн хувьд сул хөгжилтэй жалга дайран гарах бөгөөд энд рельефийн онцлогоос шалтгаалан хөрсний тархалтад нөлөөлсөн байна. Энд, жижиг жалга, судгийн хөндий орчмоор бичил рельефийн нөлөөллийн улмаас чийг хуримтлагдах нөхцөл үүсэж хээржсэн нугын шинжтэй хүрэн хөрс 2.8 га талбайтай байна. Мөн түүнчлэн ердийн хөрсөн замын улмаас элэгдэлд өртсөн хүрэн хөрсний хэмжээ 0.74 га буюу нийт төслийн талбайн 2.5%-ийг эзэлж байна. Судалгаагаар Төслийн талбайн хэмжээнд элэгдэлд өртсөн хүрэн хөрс усаар элэгдэх элэгдэлд хамгийн өндөр хувьтай өртөж байгаа буюу дунджаар 0.055 тн/га байна. Нугын шинжтэй хээржүү хүрэн хөрс дунджаар 0.03 тн га бол, хүрэн хөрс 0.05 тн/ га байна. Төслийн талбайд нийтдээ нэг жилд 181.84 тн хөрс элэгдэлд өртөж байна.

2.7. Ургамалын нөмрөг

Баруун-Урт 70 МВт дулааны цахилгаан станц төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалтаар Дундад Халхын хээр болон Дорнод Монголын хээрийн тойргийн хил залгаа бүс нутагт байрлах бөгөөд ургамалжилтын хувьд жинхэнэ хээрийн үетэн-шарилжит, Харгана оролцсон үетэн-шарилжит гэсэн хоёр төрлийн ургамал бүлгэмдэл тархан ургаж байна. Төслийн талбайд үет ургамлаас том хялгана (*Stipa grandis* P.Smirn.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Нангиад түнгэ *Leymus chinensis*, тохиолдох бол алаг өвснөөс Адамсийн Шарилж (*Artemisia Adamsii* Bess.), Шүүрэн шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Шүлхий шарилж *Artemisia pectinata*, Агь (*Artemisia frigida* Willd.) гэх мэт ургамлууд төслийн талбайд түгээмэл тохиолдох бол сөөг ургамлаас 2 зүйл харгана буюу Бяцхан навчит Харгана (*Caragana microphylla* (Pall.) Lam.), Нарийн навчит Харгана (*Caragana stenophylla* Pojark.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Марал навчит Гичгэнэ (*Potentilla tanacetifolia* Willd.ex Schlecht.), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Цуулбар багваахай (*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), Завсрын ноцоргоно (*Lappula intermedia* (Ldb.) M.Pop.), Замын таван салаа *Plantago depressa* Willd., Налчгар Хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Bge.) Juz.), Гялгар дэрс-*Achnatherum splendens* (Trin.) Nevski., гэх мэт ургамлууд төслийн талбай болон ойр орчимд нь тохиолдож байна. Харин төслийн талбайд ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйл тохиолдоогүй.

2.8. Амьтны аймаг

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь Монгол орны хөхтөн амьтдын мужлалаар 4-Монгол дагуурын тойрогт багтаж байна. Төслийн талбай нь бүхэлдээ цагаан зээрийн тархац нутагт хамаарна. Монгол улсын нутагт 2000 оны байдлаар цагаан зээр 14 аймгийн 113 сумын 500.000 орчим ам дөрвөлжин км талбайд тархаж (Лхагвасүрэн 2000) байжээ. Энэ судалгаагаар Цагаан зээр манай орны зүүн болон зүүн өмнөд нутагт харьцангуй тогтвортой байршилтай болж 516982 км² талбайд тархах болсныг тогтоосон байна. Цагаан зээрийн сүрэглэлт газар бүр харилцан адилгүй байсан бөгөөд Дорнод аймагт 54-45000, Сүхбаатарт 1-8700, Төв, Хэнтийд 2-5500 хүртэлх бодгалиар сүрэглэж байхад Өмнөговь аймагт 26-109, Дундговь аймагт 2-167, Дорноговь аймагт 1-271 бодгалиар тус тус сүрэглэж байв. Сүрэглэлтийн зургаас харахад 101-1000 бодгальтай сүрэг (32.6%) Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт зонхилон байршиж байна. Сүхбаатар аймагт Цагаан зээрийн 1 км² талбай дахь нягтшил 0.21, сүргийн нягтшил 0.0039, нөөц ойролцоогоор 15523 бодгальтай.

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт судлаачдын тодорхойлсноор 9 багт хамаарах 23 зүйл шувуу нүдээр үзэн тэмдэглэсэн байна. Үүнээс, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт 6 төрлийн 7 зүйл шувуу тохиолдох боломжтой гэсэн судлаачдын судалгааны үр дүн бий. Эдгээр 7 зүйл шувууд нь “Монгол орны шувууны улаан данс (2011)”-ны Бүс нутгийн болон Олон улсын үнэлгээгээр “Анхааралд өртөхөөргүй” статустай, өргөн тархацтай элбэг зүйлүүд юм (Gombobaatar, S., Monks, E.M., Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J.E.M., Boldbaatar, Sh., Uugangayar, Ch., 2011, pp. 847-856).

2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг

Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь ямар нэгэн улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Баруун-Урт сумын хэмжээнд Улсын ТХГН-ийн мэдээллийн санд бүртгэлтэй аймгийн болон сумын тусгай хамгаалалтад авсан нийт 13 газар байдаг.

2.10. Түүх, соёлын дурсгалт газар

Баруун-Урт Дулааны цахилгаан станц төслийн талбай нь улсын болон орон нутгийн бүртгэлтэй түүх соёлын дурсгалт газруудтай давхцалгүй. Төслийн талбайд археологийн шинжлэх ухаанд мөрддөг арга зүйг баримтлан археологийн нарийвчилсан хайгуулыг хийсэн бөгөөд тус талбайгаас ямарваа нэгэн түүх, археологийн дурсгалт газар илэрээгүй. Мөн ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн судалгааны баг Палеонтологийн хайгуул судалгааны ажлыг явуулсан ба Хайгуулын явцад ямар нэгэн эртний амьтан ургамал олдоц илэрээгүй болно. Иймд тус төслийн хэрэгжилтээс хотын түүх соёлын дурсгалт зүйлс, газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

Харин барилгын ажлын явцад өмнө нь судалж тогтоож чадаагүй түүх, соёлын дурсгал илэрсэн тохиолдолд ажлыг зогсоож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авах шаардлагатай

2.11. Нийгэм эдийн засгийн байдал

Хүн ам зүй: Сүхбаатар аймагт 2025 оны байдлаар 19.72 мянган өрхийн 66.5 мянган хүн суурин амьдарч байгаа ба Баруун-Уртад хот нийт хүн амын 50.8 хувийг эзэлж байна.

Нийгмийн хөгжил, хүний нөөцийн чадамжийн хувьд Баруун-Урт хотын Ерөнхий боловсролын сургуулиуд, ШУТИС-ийн салбар зэрэг мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагууд ажиллаж байна. Мөн Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагууд ажиллаж байна.

Эдийн засаг хөгжийн хувьд Баруун-Урт хот нь Хөдөө аж ахуй болон Уул уурхай хосолсон "Хос тулгуурт" эдийн засагтай. Хотоос урд зүгт 13 км-ийн зайд Төмөртийн Овоогийн цайрын уурхай идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг дагасан туслах үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээ хотын эдийн засгийн засагт их хувь нэмэр болдог. Хотод арилжааны банкуудын салбарууд уул уурхай, барилга, худалдаа үйлчилгээний чиглэлийн 260-аад аж ахуйн нэгж, байгууллага тогтвортой ажиллаж байна. [Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл хувьд Сүхбаатар аймаг нь малын чанар (Дарьганга, Үзэмчин үүлдэр) болон тоо толгойгоор дэлхийд дээгүүрт ордог.

Хот байгуулалт, орон сууцжуулалтын хувьд гэр хорооллын дэд бүтэцтэй амины орон сууцны хороолол "Гэр хорооллын дахин төлөвлөлтийн жишиг хот" хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба одоогоор хотод 1100 орчим өрх нийтийн орон сууц, бусад өрхүүд хувийн сууц, гэрт

амьдарч байна.

Авто зам, тээвэр логистикын хувьд Баруун-Урт хотоос Бичигт боомт чиглэлийн хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжиж байна. Мөн Бүсийн чанартай тойрог замуудыг өөр хооронд нь холбосон, хотын доторх дэд авто замуудыг шинэчлэн өргөтгөж байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Баруун-Урт хотын 70 МВт-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн эзэмшил талбайн хэмжээ нь 30 га байна. Үүнээс барилга байгууламж баригдах талбайн хэмжээ нь 7.54 га байна.

Дулааны цахилгаан станц нь нийт 283 Гкал/цаг үйлдвэрлэх хүчин чадалтай 2 зуух, эргэлтийн усны тоноглол, үнс шаарга зайлуулах төхөөрөмж, ус бэлтгэлийн төхөөрөмж, цахилгааны төхөөрөмж, хяналт удирдлагын систем зэрэг бусад тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон байна. Төслийн 6 дахь жилээс хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Нүүрсээр ажилладаг станцын яндангаар хаягдах агаар бохирдуулагчдын тоо хэмжээ нь хэрэглэх нүүрсний чанар болон хэмжээ, утаа шүүх технологиудаас ихээхэн хамаарна. Мөн түүнчлэн нүүрсийг тээвэрлэн авчрах, хадгалах, хаягдал үнс, шлагыг зайлуулах үйл ажиллагаанууд нь агаар бохирдуулах эх үүсвэр болох боломжтой. Дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор жилд дунджаар 1027.8 мянган тонн хүлэмжийн хий агаар мандалд ялгаруулах ба энэ нь Монгол улсын хүлэмжийн нийт ялгаруулалтын ойролцоогоор 3.4%-р нэмэгдүүлэхээр байна.

Төслийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийг ажлын талбай дээр авчрах, бетоны хольц, хог хаягдлыг тээвэрлэх, ачих буулгах, машин техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хөдөлгөх үед ажлын талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг доройтох, ил задгай барилгын хог хаягдлаар бохирдох, тоос, дуу чимээний бохирдол ихсэх зэрэг түр зуурын нөлөөллүүд үүснэ.

3.1. Төслийн гол сөрөг нөлөөллүүд

Агаарын чанарт: Станцаас үүсэх гол сөрөг нөлөөлөл түүний хаягдал утааны орчны агаарын чанарт нөлөөлөх асуудал юм. Мөн ажлын байрны агаарын чанар дуу шуугианы түвшин ажилчдын эрүүл мэнд сөрөг нөлөөлж болзошгүй байна. Орчны агаар дахь хүхэрлэг хийн агууламж нэмэгдэх нь олон талын сөрөг нөлөөлөлтэй ба өндөр агууламжтай үед гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.

Газрын гадарга хөрсөн бүрхэвч: Төслийн бүтээн байгуулалт болон ашиглалтын үед төслийн талбайд 7.94 га талбайд төслийн бүтээн байгуулалтын барилга, байгууламж баригдах бөгөөд үүнээс нугын шинжтэй хүрэн хөрстэй талбайд 0.74 га, хүрэн хөрстэй талбай 7.19 га талбайг эзэлж байна. Өөрөөр хэлбэл төслийн нийт талбайн 26.85%-д хөрсөн бүрхэвч хуулагдах, элэгдэл эвдрэлд хүчтэй орох төлөвтэй байна. Хөрсөн бүрхэвч дунд, хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөх нийт талбай 21.61 га буюу төслийн талбайн 73.15%-ийг эзэлж байна. Үүнээс техноген нөлөөлөлд дунд зэрэг өртөх хүрэн хөрс 19.43 га (65.8%), хээржсэн нугын шинжтэй хүрэн хөрс 7.19 га (24.3%) талбайг тус тус эзэлж байна. Төслийн бүтээн байгуулалтын явцад хөрс, газрын гадаргад дараах болзошгүй сөрөг нөлөөлөл учирч болзошгүй байна.

Усан орчинд: Баруун-Урт дулааны цахилгаан станцаас гадаргын ус буюу нуур, тойрмуудад үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь тоос, тоосонцор юм Дулааны станцын яндангаас гарах тоосны хамгийн ихээр тооцсон загварчлалын үр дүнгээс харахад төслийн талбайн урд зүгт байрлах Шороон цагаан нуур, Давст нуур, Тасархайн нуур зэрэг ус, намгархаг газарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Шовдол-Овоо газрын доорх усны ордын усны нөөцийн хэмжээ нь “С” зэрэглэлээр 3500 м³/хон гэж батлагдсан байна. Эндээс үзэхэд төслийн хүрээнд байгуулагдах дулааны цахилгаан станцын ус хэрэглээг Шовдол-Овоо газрын доорх усны ордоос хангахад тус ордын ус ашиглах боломжит нөөцийн хэмжээ нь хүрэлцэхгүй байхаар байна.

Ургамалан бүрхэвч: Төслийн талбайд одоогоор ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд ямар нэгэн сөрөг нөлөөлөлд өртөөгүй байна. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутагт хэрэгжих 70 мВт “Дулааны цахилгаан станц” барих төсөл нь нийт 29.5 га талбайд хэрэгжих бөгөөд үүнээс 8 га талбайд барилга байгууламж, зам талбай байгуулж ургамал нөмрөгт шууд нөлөөлөл үзүүлэхээр байна. Уг дулааны цахилгаан станцыг байгуулахад хатуу хучилттай

авто замын нөлөөгөөр хамгийн их талбай буюу 2.75 га, нүүрс ачиж буулгах талбай 1.71 га талбайн ургамал нөмрөг шууд нөлөөлөлд өртөх бол бусад барилга байгууламжийн нөлөөгөөр талбай 3.55 га талбайн ургамал нөмрөг шууд нөлөөлөлд өртөхөөр байна.

Амьтны аймагт: Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт зарим төрлийн шавжийн амьдрах орчныг устгах, төслийн үйл ажиллагаанаас гарах дуу чимээнээс амьтан, шувууд дайжих, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон уурхайн тээврийн зам нь зарим амьтадын нүүдэлд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Мөн шөнийн цагаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулах ба дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлөхөөр байна. Талбайн ургамал нөмрөг шууд нөлөөлөлд өртөхөөр байна.

3.2. Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрд үзүүлж болзошгүй нөлөөлөл

Хүснэгт №3-1.

№	Үзүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлий рельеф	Их	2026 онд шинээр газар шорооны ажил хийгдэх үед тоосжилт үүснэ. Зураг төслийн дагуу газар шорооны ажил хийгдэнэ.
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдлаас ил барилга угсралтын ажиллагаа шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй байдлаас барилгын ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсэж орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Дунд	Барилгын ажил болон техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Барилгын талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Дунд	төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй, гүний усны түвшинд шүүрлийн ус зайлуулах түвшинд барилгын ажил явагдахгүй учраас дунд зэргийн нөлөөлөл үүсгэнэ.
5	Хөрс газрын гадарга	Их	2026 онд бүтээн байгуулалтын явцад хөрс хуулалт хийгдэнэ.
6	Ургамал	Дунд	Ургамлан нөмрөгт нөлөөлөх зүйл бага
7	Амьтан	Нөлөөлөхгүй	Барилгын талбай нь суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө дайжсан учир төслөөс амьтанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.
8	Дуу чимээ доргилт чичиргээ	Дунд	Барилгын материал буулгах, ачих, тээвэрлэх зэргээс үүсэх дуу чимээ чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй
9	Үнэр	Бага	Ажилчдын кемпийн ахуйн хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүй, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй зэргээс тухайн орчин нь үнэр үүсгэж болзошгүй тул барилгын ажлын эхний шатанд төлөвлөлтийг зөв хийх, үйл ажиллагааны турш нөлөөллийг бууруулах ажиллах боломжтой.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь 2026 онд явагдах барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд нэмэлт тодотгол хийх ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад буюу 2026онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав. дагуу боловсруулав. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө;
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө;
3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;
5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр;
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө;
8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт №4-1.

Д/д	Авах арга хэмжээ	Зардал, төгрөг 2026
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө;	6,918,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө;	-
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө;	3,100,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;	4,540,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,660,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө;	
8	Орчны тохижилт, нэхэн сэргээлтийн төлөвлөгөө;	600,000
Нэг жилийн нийт зардал, төгрөг		17,818,000

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Баруун-Урт хотын 70 МВТ-ын дулааны цахилгаан станц төсөл”-ийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын хүрээнд тус төслөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд, нөлөөлөх нөлөөллийг энэ тайлангийн 4-р бүлэгт тодорхойлж, нөлөөллийг бууруулах чиглэлээр хийх ажлуудыг 5-р бүлэгт зөвлөсний үндсэн дээр сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг дараах хүснэгтээр харуулав.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ба зардал

Хүснэгт №5-1.

